



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2017 оны 9 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 142

Улаанбаатар
хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

1. “Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай” Ерөнхий сайдын 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 62 дугаар захирамжийн 1 дүгээр зүйлийн “Уул уурхайн сайд” гэснийг “Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд” гэж, “Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд” гэснийг “Байгаль орчин, аялал жуулчлалын сайд” гэж, 2 дугаар зүйлийн “Ашигт малтмалын газрын дарга” гэснийг “Ашигт малтмал, газрын тосны газрын дарга” гэж, “Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга” гэснийг “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга” гэж, “Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга” гэснийг “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга” гэж, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын албаны зохицуулагч” гэснийг “Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын албаны зохицуулагч” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Мөн захирамжийн 2 дугаар зүйлийн “-Газрын тосны газрын дарга;” гэснийг хассугай.



Монгол Улсын Ерөнхий сайдын
үүрэг гүйцэтгэгч

Ж.ЭРДЭНЭБАТ